



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН
ТУГИЙН ОДОНТ
АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 21 өдөр

Дугаар 8/25

Улаанбаатар хот

Г Томилолтоор ажиллуулах тухай Т

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн А/52 дугаар тушаал, Арьсны өвчин судлалын үндэсний төвийн дүрмийн 7.1.3, 12.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Баянхонгор аймгийн Галуут, Бөмбөгөр сумдад 2024 оны 06 дугаар сарын 24-27-ний өдрүүдэд “Зонхилон тохиолдож буй арьсны өвчнүүдийн орчин үеийн эмчилгээний чиг хандлага, урьдчилан сэргийлэлт” сэдэвт багц сургалтыг зохион байгуулж байгаатай холбогдуулан орон нутагт ажиллах Лабораторийн тасгийн эрхлэгч, их эмч Ж.Энхжаргал, Эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн тасгийн сувилагч З.Цэцэгмаа, Аж ахуйн албаны жолооч А.Буянцогт нарт томилолтоор ажиллах хугацаанд албан ажил үүргийг зохицуулж ажиллахыг даалгасугай.

2.Дээрх албан хаагчдын орон нутагт ажиллах зардлыг төсвийн дотоод албан томилолтын зардлаас тооцож олгохыг Санхүүгийн алба (Б.Мядаг)-нд зөвшөөрсүгэй.

3.Ажлыг холбогдох журам, удирдамжийн дагуу чанартай зохион байгуулж, тайланг гурав хоногт багтаан танилцуулахыг их эмч Ж.Энхжаргал, сувилагч З.Цэцэгмаа нарт даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн алба (Ж.Өүлэндарь)-нд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Ц.УРАНЧИМЭГ



1424010313

D:\AӨСҮТ\Б тушаал\2024.docx

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн
Захирлын 2024 оны 26. дугаар сарын 21.-ний өдрийн
А/25 тоот тушаалтын хавсралт

**“ЗОНХИЛОН ТОХИОЛДОЖ БУЙ АРЬСНЫ ӨВЧНҮҮДИЙН ОРЧИН ҮЕИЙН
ЭМЧИЛГЭЭНИЙ ЧИГ ХАНДЛАГА, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ”**

/төгсөлтийн дараах богино хугацааны сургалт/

Сургалт зохион байгууллагч байгууллага: Арьсны Өвчин Судлалын Үндэсний Төв

Сургалт үргэлжлэх хугацаа: 1 хоног /онол, дадлага 6 цаг/

Сургалт хийх байршил: Арьсны Өвчин Судлалын Үндэсний Төв

Олгох багц цаг: 1,0 кредит

Нэг удаагийн сургалтад хамрагдах хүний тоо: 50-100

Жилд зохион байгуулагдах сургалтын нийт тоо: 2

Баглах боловсон хүчний бүрэлдэхүүн:

Сургалт эрхлэгч байгууллагатай гэрээт төрийн бус байгууллага, нийгэмлэг холбоодоос зохион байгуулж байгаа сургалтын баглах боловсон хүчний бүрэлдэхүүнд сургалт эрхлэгч байгууллагын төлөөлөл оролцон сургалтын хөтөлбөр болон явцад хяналт тавьж ажиллана.

№	Овог нэр	Албан тушаал	Мэргэжил, боловсролын зэрэг	Ажилласан жил
2	Ц.Уранчимэг	АӨСҮТ-ийн захирал	АУ-ны магистр, Зөвлөхх зэрэгтэй	26
3	Ж.Энхжаргал	АӨСҮТ-ийн лабораторийн тасгийн эрхлэгч	АУ-ны магистр, Зөвлөх зэрэгтэй	26
4.	3.Цэцэгмаа	Сувилагч	Тэргүүлэх зэрэг	34

“ЗОНХИЛОН ТОХИОЛДОЖ БҮЙ АРЬСНЫ ӨВЧНҮҮДИЙН ОРЧИН ҮЕИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ЧИГ ХАНДЛАГА, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ”

Үндэслэл:

Сүүлийн жилүүдэд арьсны өвчлөл эрс ихсэж байна. Үндэсний төвийн хувьд арьс, харшлын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зонхилон тохиолдож буй арьсны өвчлөл, тэдгээрийн оношилгоо, эмчилгээний талаар аймаг, дүүрэг, нийслэлийн арьс судлалын мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд орчин үеийн оношилгоо, эмчилгээний арга зэрэг олон улсын удирдажийн дагуу ЭМДҮЗ-ийн хяналт үнэлгээ, ЭМД-ын санхүүжилтийн шаардлагад нийцсэн тусламж, үйлчилгээний талаарх цогц мэдээллийг зайлшгүй шаардлага байна. Мэргэжил арга зүйн зааварчилгаа өгөх, арьсны халдварт өвчнүүд, арьсны архаг өвчний үед үзүүлэх тусламж, үйлчилгээ нь арьсны нарийн мэргэжил шаарддаг бөгөөд өвчний эдгэрэлтэд чухал.

Уг сургалтыг арьс, харшлын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулна.

Зорилго:

- Зонхилон тохиолдож буй арьс харшлын өвчлөл, тэдгээрийн оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга, өвчний хяналт, орчин үеийн эмчилгээний чиг хандлагын талаар мэдлэг, ур чадвар, хандлагад эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдийг сургах, дадлагажуулах.

Зорилт:

- Арьсны зонхилон тохиолдож буй өвчнүүдийн орчин үеийн оношилгоо, эмчилгээний талаар онолын мэдлэг олгох
- Мэргэжил арга зүйн зааварчилгаа өгөх, арьсны халдварт өвчнүүд, арьсны архаг өвчний үед үзүүлэх тусламж, үйлчилгээний гардан үйлдлийн технологи зэмшүүлэх, далагажуулах

Зайлигүй эзэмших мэдлэг:

1. Арьс гоо заслын эмч нарт зонхилон тохиолдож байгаа арьс, харшлын өвчний урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээний орчин үеийн чиг хандлагад суралцах
2. Бусад мэргэжлийн эмч нарт /дотор, хүүхэд, өрхийн эмч г.м/ арьсны өвчний үед үзүүлэх ерөнхий мэдлэг эзэмшүүлэх
3. Эмч, сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд багаар нь арьсны өвчний үед үзүүлэх сувилахуйн тусламж үйлчилгээ, хэсэг газрын эмчилгээний арга аргачлалыг эзэмшүүлэх

Зайлигүй эзэмших чадвар:

Бусад мэргэжлийн /дотор, хүүхэд/ болон өрх, сум, багийн эмч нарт ард иргэдэд арьсны өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үр дүнтэй зөвлөгөө, мэдээлэл, эрүүл мэндийн боловсрол олгох арга барил, хандлагад суралцах.

Сургалтын арга зүй:

Багш нар судалгааны үр дүн,, олон улсын удирдамж, статистик мэдээлэлд тулгуурлан онолын мэдлэг олгох, харилцан ярилцах, үзүүлэн таниулах уламжлалт болон орчин үеийн шаардлага хангасан материал, тоног төхөөрөмжийг хэрэглэх, тохиолдол дээр хэлэлцэх зэрэг идэвхитэй сургалтын хэлбэрүүдээр явуулна.

**“ЗОНХИЛОН ТОХИОЛДОЖ БУЙ АРЬСНЫ ӨВЧНҮҮДИЙН ОРЧИН ҮЕИЙН
ЭМЧИЛГЭЭНИЙ ЧИГ ХАНДЛАГА, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ ”
эмч нарын сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөө**

№	Онолын сэдэв	Сургалтын хэлбэр /цаг/	Багшлах боловсон хүчний нэр
		Онол/ семинар семинар	
1	Арьсны идээт өвчинүүд	1 цаг 30 минут	Ц.Уранчимэг, Ж.Энхжаргал
2	Харшлын шалтгаант өвчинүүд (Хүнсний харшил, ургалмлын харшил, эмийн харшил)	1 цаг 30 минут	Ц.Уранчимэг, Ж.Энхжаргал
3	Арьс судлалын эмчилгээ оношилгооны дэвшилтэй технологиуд	1 цаг 30 минут	Ц.Уранчимэг, Ж.Энхжаргал
4	Арьсны сувилахуй	1 цаг 30 минут	З.Цэцэгмаа

Сургалт явуулахад ашиглах эх сурвалж

1. Б.Хандсүрэн “Арьсны өвчин” 2010 хуудас 195, 214-221,
2. Зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн оношлогоо эмчилгээний удирдамж хуудас 244-250, 259-265
3. С.Наранчимэг “Сувилгааны үйл ажиллагаа
4. Скрипкина Ю.К “Кожные и венерические болезни” I,II/ том, 1999
5. Fitzpatrick's “Color Atlas and Synopsis of Clinical Dermatology” sixth edition, 2009
6. Bolognia, Dermatology Jean L. Bolognia MD, Joseph L. Jorizzo MD, Julie V.